



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/39

Эмзэлтолгой

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/188 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг агаарын дулааралтай холбогдуулан цас ихтэй уулархаг газар, гуу, жалга, гол мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасаж шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Шар усны үер, мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Цаг агаарын мэдээг сумын хэмжээнд нарийвчлан, иргэдэд шуурхай хүргэх, багц мессежээр олон давтамжтайгаар дамжуулах, цасан бүрхүүл болон гол, нууруудын мөсний зузаанд хэмжилт хийж болзошгүй эрсдэлийн судалгааг гаргаж ирүүлэхийг Цаг уур ертөөний дарга (Н.Дэмбэрэл)-д,

4.Дээрх өдрүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зам тээврийн хөдөлгөөнд хяналт тавьж аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (ахмад Б.Алтангадас)-д,

5.Цахим мэдээллийн хэрэгсэлээр иргэдийг гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр баталгаагүй гарц, гарам дээр самбар байршуулах сэрэмжлүүлэх зэрэг шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг Эрэн хайх аврах салбарын дарга (Д.Даваасүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга
(Б.Өнөрбаяр)-д үүрэг болгосугай

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

